

УМАРД, ӨМНӨД СОЛОНГОСЧУУД НЭГДЭХ НЬ XXI ЗУУНЫ ТҮҮХЭН ТОМ ҮЙЛ ЯВДАЛ БОЛНО

Ц.Гүрбадам*

Монгол, солонгос үндэстнүүд угсаа гарвал, хэл ярианы язгуур үндэс, элж холдсон эртний түүх, оюун санаа, соёлын болон “худ ургийн холбоотой байсан тухай монгол, солонгосын судлаачдын бүтээлүүдэд тодорхой дурьдсан байдаг. Гэвч үүний зэрэгцээ хоорондоо дайтан тулалдаж, эвлэрэн найрамдаж, хамтарсан хүчээр бусдын эсрэг тулалдаж явсан түүх ч бий. Монголын түүхийн сурвалж бичгүүдэд “Гуулин улс”, “Ээж улс”, “Түшмэг улс” гэсэн нэр томъёо олонтаа тохиолддог.

Монгол, Солонгос хоёр улс бие даасан төр улсын хэмжээнд албан ёсоор харилцаж эхэлсэн хугацааг солонгос судлаач Б.Сумъяабаатар 1215 он гэж тодорхойлжээ. Харин манай нэрт эрдэмтэн, академич Ч.Далай “МЭ-ний 400-гаад оны үеэс Монгол, Солонгос хоёр бие даасан улсын хэмжээнд харилцаж эхэлжээ” гэж бичсэн байдаг. Үүний чацуу, МЭ-ний 995 онд Кидан гүрэн, Корё улстай харилцаа тогтоосны 1000 жилийн ойг манайд тэмдэглэсэн нь Монгол, Солонгос хоёр бие даасан улсын хэмжээнд харилцаж эхэлсний тодорхой жишээ юм гэж солонгос судлаач эрдэмтдийн олонх нь хүлээн зөвшөөрсний илрэл бизээ.

Хэдэн зуу, мянган жилийн өмнө болсон эдгээр үйл явдлын жинхэнэ он, сар өдрийг тодруулахад түмэн бэрхшээл байгаа учраас түүний талаар одоо маргалдах нь гол биш, хамгийн чухал нь монгол, солонгосчууд найрамдалт харилцаатай болсонд оршиж байгаа билээ.

Аугаа их Чингэс¹ хаан XIII зууны үеийн аян дайндаа Солонгосыг оролцууцах зорилгоор түүнийг эрхшээлдээ тайван замаар оруулах замыг сонгон авч цэргийн жанжин Хажин, Жала хоёрыг Солонгосын жанжин Жо Чун, Ким Чиро нартай хэлэлцээр

* МУИС, ОУХС-ийн профессор, доктор (Sc.D)

¹ Чингис гэх нь төдий л зөв бус Чингэс гэвэл зохистой гэж монгол хэл судлаачдын нотолсоор байгааг зөв байх гэж үзээд ийнхүү бичив.

хийлгэсний үр дүнд 1219 оны 1 дүгээр сарын 20-нд энхийн гэрээ байгуулсан бөгөөд уул гэрээнд “Бидний хоёр улс үүрд ах дүү байж, түмэн өдөр үр сад маань энэ өдрийг үл мартаг” гэж тэмдэглэсэн нь манай хоёр улс, ард түмний түүхийн нэн чухал баримт бичиг юм. Ийм ч учраас БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жүн 2000 онд манай улсад айлчлахдаа: “Хоёр улс үүрдийн ахан дүүс болж үеийн үед энэ өдрийг мартахгүй байя”² гэсэн нөхөрсөг тангарагыг Чингэс хааны үед тавьж байсан тухай манай УИХ-ын индэр дээрээс хэлж байсан нь сэтгэлийн хөөрлөөр хэлсэн санамсаргүй үг огтхон ч бишээ.

Чингэс хаан 1227 онд таалал төгссөний дараа Өгөөдэй хааны үе эхэлсэн бөгөөд түүнээс хойшхи жилүүдэд Солонгосын тал Монголд алба төлөхөө зогсоосон учир Өгөөдэй хаан Солонгос руу гурван удаа цэргийн хүчээр довтолсон боловч нас барсан. Түүний дараа хаан ширээнд суусан Гүюг, Мөнх хаадын үед монголчууд зургаа дахь удаагаа Солонгос руу довтолж олон хот, далайн боомтуудыг нь эвдлэн сүйтгэснээс хоёр талын харилцаа эрс хурцдаж муудсан ажээ. Гэвч Чингэсийн байгуулсан Их Монгол улс мөхөж Хубилай хаан ширээнд суусныхаа дараа Солонгос улсыг бусдаас нэн чухалд үзэх болсон байна. Тэр үед Солонгосын ван Вон Жон Хубилай хаанд нэн үнэнчээр хүчин зүтгэсэн тул түүнтэй худ ургийн холбоотой болохоор шийдэж ганц охин Хутагбэхээ хөвгүүнийх нь хатан болгон өгчээ.

Вон Жон ван төр барих хугацаандаа Солонгосын нутгийг монголчууд Япон руу довтолж дайны түшиц газар болгох, Чэжү, Масаны онцгой район байгуулахад нь Хубилай хаанд хүчин зүтгэж байжээ.

Хубилай хааны Юан улс Гуулин улсыг эрхшээлдээ оруулсан төдийгүй 1274, 1281 онуудад Японыг дайлахаар хоёр удаа довтолоход солонгосчууд оролцож байсан. Иймээс ч Монголын довтолгоонд өртсөн нутгийн япончууд хүүхдээ уйлахад нь “Монгол, солонгосчууд ирнэ шүү” хэмээн хэлж, айлган тайтгаруулдаг үг хэллэг хүртэл гарсан тухай зарим судлаачид бичсэн нь ортой байж болох юм.³

Хубилай хаан 1294 онд нас нөхцсөний дараах үед болсон нэгэн онцгой зүйл бол Хайсан хүлэг Юан гүрний хаан ширээнд суух, Чун Сон Солонгосын ван болох хоёр үйл явдал нэгэн зэрэг давхцсан төдийгүй улмаар Хайсан хүлэг солонгос хатантай, Чун Сон монгол хатантай болсон тул хоёр орны харилцаа нэн таатай нөхцөлд хөгжих болсон ажээ. Ийнхүү Хубилай хааны удмын эрлийз хаад 108 жил Солонгост төр барьж байсан бөлгөө.

² Монгол улс, Бүгд Найрамдах Солонгос улсын харилцаа 10 жил: Баримт бичгийн эмхэтгэл. Сөүл. 2000. 195 дахь тал.

³ Т. Мөнхцэцэг. Зүүн Хойд Азийн төлөв байдал ба Монгол улс. Улаанбаатар. 2003. 37 дахь тал.

Эдүгээ үеийн зарим жишээ дурьдвал, Тэрэлж голын орчимд байдаг Гүнжийн сүм, Солонгосын өмнөд хэсгийн далайд буй Чезу арал, монгол морьдыг олон хүн үзэж сонирхсоор байна.

Энэ бүгд нь монгол, солонгосчууд өнө эртний уламжлалт түүхэн холбоогоо умартаагүй, XXI зууны шинэ орчин нөхцөлд үргэлжлүүлэн хөгжүүлж байгаагийн нэгэн бодит илрэл бизээ.

Миний бие 1950 онд Улаанбаатар хотын 1-р арван жилийн дунд сургуулийн сурагч байхдаа БНАСАУ-аас Монголд ирсэн төлөөлөгчдийн үгийг анх удаа сэтгэл догдлон сонсож, Солонгос улс 1945 оны 8 дугаар сарын 15-нд Японы колоничлолоос чөлөөлөгдсөн боловч 1950 оноос эхэлсэн Умард, Өмнөдийн хооронд АНУ, ЗХУ, БНХАУ-ын шууд оролцоотойгоор асар ширүүн дайн байлдаан болж байгааг анх мэдсэн юм. Удалгүй энэ дайны уршгаар өнчирсөн 200 гаруй хүүхэд, багш нар манай улсад ирсэн бөгөөд тэдгээрт зориулан Зайсан толгойн зүүн хөвөөнд тусгай сургууль, орон сууц барьж хичээл, ном зааж, асран халамжилсан билээ. Түүнээс хойш Солонгосын дайн хүчтэй өрнөж байсан жилүүдэд Москва хотноо БНАСАУ-ын болон ЗХУ-ын солонгос хөвгүүд, охидтой нэг сургуульд суралцаж, заримтай нь нэг байранд амьдарч, олон жилийн турш үерхэн нөхөрлөсөөр явна. Энэ бүгдээс улбаалан надад солонгос хүмүүс ихэд ойр дотно санагддаг болсоныг нух юун.

БНАСАУ анх 1948 оны 9 дүгээр сарын 9-нд байгуулагдсанахаа дараа төдхөн оны 10 дугаар сарын 15-нд манай улстай дипломат харилцаа тогтоосон дэлхийн хоёр дахь орон юм. БНСУ 1948 оны 8 дугаар сарын 15-нд байгуулагдсан бөгөөд манай улс 1990 оны 3 дугаар сарын 26-нд дипломат харилцаа тогтоосон нь хөрөнгөтөн гэгдэж байсан оронтой социалист орнуудын дотроос хамгийн түрүүнд улс төр, дипломатын харилцаатай болсноороо бусдын анхаарлыг ихэд татаж байсан билээ.

1950-1953 онуудад болсон дайны төгсгөлд Солонгосын хойг дээр 38 дугаар өргөргөөр хуваагдсан хоёр улс буй болсон билээ.

Төрийн бодлого, шударга ёс, хүний эрх, хүмүүнлэгийн талаас авч үзвэл монгол, солонгосчуудын хувь тавилан их ойролцоо бөгөөд дэлхийд хуваагдмал байдлаар амьдарч буй цөөхөн үндэстнүүдийн нэг юм.

Улс орон, ард түмний хоорондын харилцаа нь дайтах ба найрамдах, өрсөлдөх ба хамтран ажиллах, нутаг дэвсгэрийг булаах ба зэрэгцэн орших, тэмцэлдэх болон эвсэхийн эцэс төгсгөлгүй солбилцол гэдгийг нотолж байна. Ингэж олон зууны туршид

ээнт улс, колони, метрополи, ивээн эзэрхэх дэглэм, автономи, сувернитет, тусгаар тогтнол, холбоо, конфедерац, хамтын нийгэмлэг гэх мэт улс хоорондын харилцааны янз янзын хэлбэрүүд бүрэлдэн тогтжээ. Үүнийг орчин үеийн улс төрийн газрын зураг бэлээхэн харуулж байна.

XX зууны дундуур Африк, Ази, Латин Америкт колоничлолын систем нурж, тусгаар тогтносон хэдэн арван шинэ улс бий болсон. XX зууны эцэст дэлхийг донсолгосон хамгийн том үйл явдал нь Зөвлөлт Холбоот улс задран унасанд оршино. Үүний үр дүнд “Эрх чөлөөт” улсуудын “эвдэршгүй холбоо”-ны хэлтэрхий дээр тусгаар тогтносон 15 улс үүссэн билээ. Хиймлээр байгуулагдсан Югославын холбооны улс цус урсгасан дотоодын сөргөлдөөний улмаас хэд хэдэн бие даасан улс болон бутарлаа. Түүнээс илүү бас нэг чухал үйл явдал бол дайн байлдаан, эзэрхэн түрэмгийлэгчдийн харгис бодлогын улмаас хуваагдаж тусгаарлагдаад байсан Герман, Вьетнам хоёр нэгдсэн улсаа сэргээсэн түүхэн амжилт байлаа.

Гүн нойрсож байсан паназиатизм сэргэж байна. Ази сэрснээр дэлхийд ямар өөрчлөлт гарах бол хэмээн газар сайгүй сонирхож эхэллээ.

Үүнтэй зэрэгцэн тусгаар тогтнох эрхээ эдлэх эрмэлзэл, салан тусгаарлах хандлага улам хүчтэй болсоор байна. Кавказын бүс нутагт үндэсний тусгаар тогтнолын төлөө ширүүн дайн болсон бөгөөд уул тэмцэл одоо ч төгсөөгүй бөгөөд мөн ийм байдал Ази, Африкийн нилээд улсад үргэлжилсээр байна.

Эзлэн түрэмгийлэгчид найрлаж цэнгэх үедээ бялуу огтлон хуваадаг шигээ Монголын уугуул газар нутгийг Ар Монгол, Өвөр Монгол, Буриад Монгол, Тагна-Тува гэсэн дөрвөн том хэсэг болгон бүр ч жижиг хэсгүүдэд хуваасан билээ. Монголчууд хүчээр хуваагдсаны гашуун үр дагаврыг гурван зууны туршиж амсаж ирлээ. Иймээс ч тэд бие бие рүүгээ тэмүүлэн нэгдэхийг эрмэлзэх нь зүйн хэрэг. Түүхийн тодорхой үеүдэд монголчууд нэгдэхийг нэг биш удаа оролдож, энэ нь талаар өнгөрч байсан хэдий ч нармай Монголын үзэл санаа бүрмөсөн алга болж мөхөөгүй цаашид ч бадарсаар байх болно. Учир нь энэ үзэл санаа бол бүх монголчуудын олон зуун жилийн мөрөөдөл, тэдний үндэсний ухамсрын эрхэм дээд үнэт зүйл билээ.

Яагаад ийм өөдрөг дүгнэлт хийж байна гэвэл, нэгд, үндэстнүүдийн асуудал хүн төрөлхтний түүхийн асуудал байсаар ирсэн бөгөөд XXI зуунд улам хурцаар тавигдах болно. Хоёрт, эрдэмтдийн таамаглалаас үзвэл энэ зуунд үндэстнүүд тусгаар тогтнолоо олох шинэ түүх эхэлж, шинээр олон тооны бүрэн эрхт улс үүсэх магадлалтай. Гуравт,

үүний нөлөөн дор бүх монголчуудын үндэсний ухамсар, нэгдэх эрмэлзэл нь улам өсч, магад ч үгүй XXI зуунд монголчууд нэг үндэстний хувьд нэгдэх үйл хэрэгтээ урьд өмнө сонсогдоогүй шинэ мэдээг дэлхий ертөнцөд дуулгаж ч мэднэ.

Эдүгээ XXI зууны эхэнд умард ба өмнөд солонгосчууд, курдууд, манай монголчууд олон хэсэгт хуваагдсан хэвээр өнө удаан жилүүдийг өнгөрүүлсээр байгаа цөөхөн үндэстнүүд хэвээр үлдсэн нь эдүгээгийн соёлт хүн төрөлхтөний нэгэн гутамшиг, эмгэнэл, хар толбо мөн гэлтэй. Өөр өөр улсад хуваагдан амьдрахын бүхий л зовлонг амссаар ирсэн монголчууд Умард, Өмнөд солонгосчуудын нэгдэж нэгэн улс, нэгэн гэр бүл болж амьдрах гэсэн хүсэл мөрөөдөл, тэмцэл чармайлтыг сэтгэл зүрхээрээ ойлгон дэмждэг нь энэ бүхэнтэй холбоотой.

Умард, Өмнөд Солонгостой Монгол улс нэгэн адил найрсаг харилцаатай байсныг дараах албан ёсны дээд хэмжээний уулзалтууд юун түрүүнд харуулж байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал тэргүүтэй Засгийн газрын төлөөлөгчид анх удаа БНАСАУ-д 1956 оны 10 дугаар сарын 11-нд айлчилсны дараа 1961 онд БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу, 1986 онд МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, АИХ-ын тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх, 2004 онд Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабанди нар тус тус нам, төрийн шугамаар айлчилжээ.

БНАСАУ-ын Сайд нарын Танхимын дарга Ким Ир Сен тэргүүтэй Засгийн газрын төлөөлөгчид анх удаа 1956 оны 7 дугаар сард манай улсад айлчилсан бөгөөд дараа нь Ким Ир Сен Солонгосын хөдөлмөрийн намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНАСАУ-ын Ерөнхийлөгч байхдаа 1988 оны 6 дугаар сарын 7-нд хоёр дахь удаагаа айлчилсан байна. Мөн 1959 онд БНАСАУ-ын АДХ-ын Тэргүүлэгчдийн дарга Цой Ен Ген, 2007 онд БНАСАУ-ын АДХ-ын Тэргүүлэгчдийн дарга манай улсад айлчилжээ.

Монгол улс БНСУ-тай дипломат харилцаа тогтоосны дараа Ерөнхийлөгч П.Очирбат 1991 оны 10-р сард анх удаа төрийн айлчлал хийсэн бол дараа нь 2001 онд Ерөнхийлөгч Н.Багабанди, 2007 онд Ерөнхийлөгч Н.Энхбаяр нар айлчилсан байна.

БНСУ-ын талаас анх удаа Ерөнхийлөгч Ким Дэ Жүн 1999 онд, дараа нь Ерөнхийлөгч Ро Му Хён 2006 онд Монгол улсад төрийн айлчлал хийсэн билээ.



Ю. Цэдэнбал, Ким Ир Сен нар
1956 онд анх удаа уулзаж байгаа нь



Ю. Цэдэнбал, Ким Ир Сен нар
гэрээнд гарын үсэг зурсан нь

Дээд хэмжээний эдгээр айлчлал, гэрээ, хэлэлцээрүүдийн дотроос Ким Ир Сений тухай нэгэн зүйлийг тодруулан өгүүлье. Тэрбээр биеийн эрүүл мэндийн хувьд зарим бэрхшээлтэй байсан боловч 1956, 1988 онуудад албан ёсны айлчлал манай улсад хийсэн бөгөөд Москва орох замдаа нэг удаа манайхаар дамжин өнгөрч байжээ. Хоёр их хөршийн маань тэр үеийн удирдагчид И.Сталин, Мао Цзедун, Н.Хрущев нарын нэг нь ч Монголд ирж байгаагүйг бүгд мэднэ.

Ким Ир Сен 33 настайдаа БНАСАУ-ын удирдагч болж 82 насандаа ертөнцийн мөнх бусыг үзүүлэх хүртлээ тэр үеийн социалист орнуудын удирдагчдаас хамгийн урт насалж эх орныхоо төлөө хүчин зүтгэх хугацаандаа “Видэхан Сүрённам” буюу “Аугаа их Жолоодогч” гэсэн алдар хүндийг ард түмнээсээ хүртсэн бөлгөө. Тэрбээр манай улсын удирдагчидтай элэгсэг дотно харьцаатай байсан тул Монгол улсыг эдийн засгийн хувьд бие даан хөгжүүлэхэд чиглэсэн зөвлөлгөө, бодлоо элэн далангүй хэлдэг байжээ. Энэ талаар ШУА-ийн ОУС-ын Хүрээлэнгийн ажилтан К.Дэмбэрэлийн бичсэн “Ким Ир Сен ба БНМАУ” гэсэн сонирхолтой түүхэн эх сурвалжаас заримыг нь зориуд товчлон авч уншигчид, судлаачиддаа толилуулъя.

Монголын аль ч түвшний хүмүүстэй уулзахдаа Ким Ир Сений дурсан ярих дуртай зүйлийн нэг бол “Эх орноо чөлөөлөх дайны үед болон дайны дараах сэргээн босголтын үед ч Монголын ард түмэн манай ард түмэнд эд материалын болон сэтгэл санааны тусламж, дэмжлэг үзүүлж байсныг бид мартахгүй” гэсэн дурсамж байлаа.

Солонгосын хойгийн дайн нь Ази дахь “хүйтэн дайны” эхлэл төдийгүй хоёр системийн зөрчлийг бодитой болгож өгсөн хэмээн үзэх үндэстэй. Системийн зөрчилд зөвхөн нэг талын эрх ашигт үнэнч байсан БНМАУ-ын зүгээс БНАСАУ-ыг холбоотноо хэмээн үзэж ядмаг эдийн засгаа үл хайхран бололцоотой бүхнээрээ тусалж байсан билээ.

Ким Ир Сен: “Би 1956 онд танай оронд айлчилснаас гадна 1952 онд Москва орох замдаа нэг удаа дамжин өнгөрч байсан. Миний нэг охин уушигны өвчтэй болж ЗХУ-д

эмчлүүлээд буцахдаа танай нутгаар надтай хамт явж байв. Нөхөр Ю.Цэдэнбал миний охины өвчтэйг мэдэж айргаар эмчлэхийг зөвлөн олон удаа айраг явуулж байсан. Охин маань жилийн дараа бие нь эрүүл болсон. Танай айраг эмчилгээний сайн чанартай юм билээ” гэж магтаж байжээ.

Тэрбээр Монгол улсын төмрийн хүдэр болон бусад ашигт малтмалын нөөцийг сонирхохын хамт улс орноо үйлдвэржүүлэх бодлогоо тодруулахдаа “...юуны түрүүнд машины аж үйлдвэрийг хөгжүүлэх хэрэгтэй. Яагаад гэвэл машины үйлдвэрийг хүнд аж үйлдвэрийн зүрх гэж ярьдаг юм. Иймээс бүр дайны үед манай оронд машины аж үйлдвэрийн суурийг тавьж, суурь машины үйлдвэр барьж эхэлсэн... Танай орон төмрийн хүдэр, коксждог нүүрсээр баян байна. Иймээс төмрийг үйлдвэрлэж, улмаар гадаадад гаргаж болох байна. Ган төмрийг хайлуулдаг болсон үед машины үйлдвэр хөгжүүлж болно. Ер нь өсөн нэмэгдэж буй хүн амыг дан ганц мал аж ахуйгаар тэжээж чадахгүй. Иймээс газрын доорх баялгийг нээж ашиглахыг бодох хэрэгтэй. Танайд коксждог нүүрс их байна. Гэтэл манайд коксждог нүүрс байхгүй. Бид Монголоос коксждог нүүрс Хятадын төмөр замаар дамжуулан тээвэрлэх бололцоо байгаа эсэх талаар Хятад нөхдийн саналыг асуусан. Тэд хариу өгөөгүй байна. Зөвлөлтийн нутгаар дамжуулж Находка хүргэж тэндээс усан онгоцоор авах боломж байгаа юм. Гэвч энэ нь бас бэрхшээлтэй. Ямар ч нөхцөлд Зөвлөлт, Хятадын алинаар нь дамжуулсан ч урьдчилан тохиролцох шаардлагатай Таван толгойн коксжих нүүрсний орд газрыг ашиглах, тээвэрлэхэд бид ажиллах хүч, зарим талаар хандив оруулах боломжтой. Ямар ч аргаар хамтран эзэмшсэн энэ асуудлыг дээд хэмжээнд, тухайлбал нөхөр Горбачевыг оролцуулахгүйгээр доогуур хэмжээнд яриад бүтэхгүй” хэмээн зөвлөжээ. Таван толгойн орчимд буй зэсийн баялаг орд газрыг эзэмшихэд 450-500 км төмөр зам тавих хэрэгтэй болж байна гэж манай тал танилцуулахад Ким Ир Сен: “Энэ ч гайгүй хэрэг ... Коксжих нүүрсний орд газрыг ашиглах тээврийн асуудлыг юуны өмнө шийдвэрлэх хэрэгтэй юм. Монголын нутагт 450 км төмөр замыг төвөггүй тавьж болно. Манай улс хүнд нөхцөлд төмөр зам тавьдаг нилээд туршлагатай. Танай орон шиг байгаль, газар зүйн бэрхшээл багатай газарт нэг жилийн дотор барьж болох юм” гэжээ.

Ким Ир Сен галт тэргэнд явах зуураа Монголын талаас үдэн гаргагчидтай ярилцах зуураа дараах санааг нилээд идэвхтэй хэлж байжээ. “Бие даасан үндэсний эдийн засгийг хөгжүүлэхгүйгээр эцсийн эцэст байгаа зүйлээ гадагш гаргачихаад хоосон нүх л үлдэхэд хүрнэ. Иймд зоригтой эхлэх хэрэгтэй. Жишээлбэл, нэг машиныг гадаадын зах

зээлээс 30 мянган рубль буюу доллараар бид авч байна. Дараагийн шатанд тэд дээр нь кран зоочихоод 45 мянган рубль, доллараар өгч байна ... Бүх зүйлийг гаднаас авна гэдэг бол яваандаа тэдний гарт орно гэсэн үг. Энэ мэтчилэнгээр байгаа зүйлээ өгсөөр суутал хоосон хоцорно ...

Би нилээд эрт Индонезид айлчлах үеэр Ерөнхийлөгч Сукарно Жакарта хотын олон машиныг зааж Бээжингээс илүү байгаа биз дээ гэж асуухад нь би хариуд нь тоглоомоор: “Танай орон империалистуудын шинэ колоничлолын бодлогод автагдаж байна. Гадаадаас олон тооны машин авч түүнээ өөртөө засахгүй, сэлбэг хэрэгслийг нь авч байгаа нь аажмаар тэдний гарт орно гэсэн хэрэг. Энэ утгаар үзэхэд Хятад танайхаас илүү юм гэж хэлсэн. Маргааш нь Сукарно таны хэлснийг бодож хонолоо. Үнэхээр тийм юм гэж байсан” хэмээн бас ярьжээ.

Ким Ир Сен бүс нутгийн хүрээнд, тухайлбал Зүүн хойд Азид хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэхийн чухлыг онцлон хэлэхдээ: “Манай Ази тив, ялангуяа Зүүн хойд Азид оршин тогтнож байгаа социалист орнуудын дотор том орнуудыг эс тооцвол зөвхөн манай хоёр орон л байна. ЗХУ бол том орон, Хятад ч мөн том орон. Вьетнам, Лаос, Кампучи нь Зүүн өмнөд Азийн орнууд юм. Иймээс манай хоёр улс онцгой дотно харилцаатай байх хэрэгтэй юм” гэснээс үзвэл энэ бүс нутагт тодорхой хэмжээний найдвартай түншлэл эрэлхийлж байсны илрэл гэж дүгнэж болох талтай.

Ким Ир Сен одоогоос 20 жилийн өмнө Монголд айлчлахдаа бидний өнөөг хүртэл шийдвэрлэж чадаагүй байгаа Таван толгойн коксждог нүүрсний болон зэс, төмрийн орд газруудыг ашиглах, төмөр зам тавих, машины үйлдвэр хөгжүүлэх талаар туслах, хамтран ажиллах тухай тодорхой санал дэвшүүлж байсан нь одоо ч ач холбогдлоо алдаагүй байна.

Ким Ир Сен⁴ манай улсын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу гуайг маш их хүндэтгэдэг байсан бөгөөд хүү Ким Чен Ир нь хүүхэд байхдаа Солонгосын дайны хүнд жилүүдэд Самбуу даргын хүү Сүрэнжавтай тоглож өссөн гэдэг. Хувь хүмүүсийн хоорондох энэ мэт ойр дотнын харилцаа нь улс төрийн том бодлогыг хэрэгжүүлж ард түмнүүдийг найрамдуулахад ч чухал үүрэг гүйцэтгэдэг талтай. Үүнийг “ардын дипломат ажиллагаа” хэмээн нэг үе өндрөөр үнэлдэг байлаа.

⁴ Сүүлийн үед Ким Ир Сенийг солонгос дуудлагаар нь Ким Ил Сон, Ким Чен Ирийг Ким Жон Ил гэж бичдэг болсоныг анхаарна уу.



Ж. Самбуу, Ким Ир Сен нар

дипломатын шугамаар гаргасаар ирсэн бөгөөд одоо ч энэ чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

Зөвхөн Монгол улс төдийгүй дэлхийн олон улс гүрэн, үндэстнүүд улс төр, үзэл суртал, цэргийн бодлогын үүднээс хуваагдан таслагдсан Солонгосын хоёр улс, солонгосчуудыг нэгтгэх асуудлыг Солонгосын хойгийн аюулгүй байдлын үүднээс дэмжсээр ирснийг бүгд мэднэ. Гэвч ийнхүү хуваагдмал байгаа хоёр Солонгос улсыг нэгтгэх байтугай улам холдуулах бодлогыг АНУ-ын дайнч бүлгийн эрх мэдэл бүхий удирдагчид, улс төрчид олон жилийн турш чармайн зүтгэж БНАСАУ-ыг Иран, Иракийн нэгэн адил “муу ёрын тэнхлэг” хэмээн занан зүхэж, терроризмыг дэмжигч орнуудтай хийх тэмцлийн нэгэд тооцож улс төр, эдийн засгийн хувьд хавчих, бүр сүүлдээ цэрэг, зэвсгийн хүчээр дайран довтлох тухай дэлхий нийтэд зарлаж нэг бус удаа заналхийлж, айлган сүрдүүлсээр ирлээ. АНУ олон тооны цэрэг, цөмийн цэнэг бүхий пуужингуудаа Өмнөд Солонгост байрлуулсаар байгаа атлаа сайндаа л 1-2 цөмийн зэвсэгтэй байж болзошгүй хэмээн таамаглагдсан (Иракийг тагнуулууд нь юу гэж гүтгэлээ?!) БНАСАУ-ын цөмийн довтолгооноос сэрэмжилж байна хэмээн мэдэгддэг нь ор үндэсгүй зүйл болохыг эрэгцүүлэн бодож зөвөөр ойлгоход онцын их ухаан шаардагдахгүй. Чухамдаа эдүгээ дэлхийд 37000 гаруй цөмийн цэнэгт хошуу байлдаанд бэлэн байгаагийн 93 хувь нь АНУ, ОХУ-ынх бөгөөд түүний тэн хагас нь АНУ-ынх болох нь нууц зүйл бишээ. Ийм цөмийн зэвсэгтэй мөн, 30 гаруй мянган цэргээ БНСУ-ын нутагт байрлуулсан, Номхон далайд АНУ-ын VII флот байгаа нөхцөлд Умард Солонгосоос тэгтлээ болгоомжилж түгшүүр зарладаг нь гайхалтай бөгөөд инээдэмтэй зүйл бус уу.

АНУ-ын Ерөнхийлөгчид цөмөөрөө Умард, Өмнөд хоёр Солонгосыг нэгтгэх асуудалд хүч хэрэглэх бодлогын үүднээс байнга хандаж байсан гэж дүгнэвэл хэтрүүлсэн

зүйл болно. Тухайлбал, АНУ-ын Ерөнхийлөгч байсан Ричард Никсон: АНУ үгүйгээр Номхон далайн гурвалжин гурван хөлтэй сандал мэт тогтворгүй, цаашид аюултай болно. Япон, Хятад, ЗХУ-ын бүс нутагтаа ноёрхох гэсэн өрсөлдөөн байнга байх болно. АНУ нийт Зүүн Азийн орнуудын ашиг сонирхлын үүднээс саармагжуулагч байж тэр сандлын дөрөв дэх хөл нь болох ёстой гэж үзэж байсан бол Билл Клинтон: “Хүйтэн дайны” үеийн “тогтоон барих стратегийн оронд нөлөөгөө өргөтгөн тэлэх стратегийн бодлого” боловсруулан хэрэгжүүлж эхэлснийг БНСУ дэмжиж “Умардын бодлого” гэсэн шинэ үзэл баримтлалыг ямар нэгэн хэмжээгээр хэрэгжүүлэх алхам хийх болсныг зүй ёсоор үнэлэх учиртай. Эдгээр нь тухайн үеийн түвэгтэй, хурцадмал нөхцөл байдалд санаачилсан зоримог бөгөөд улс төрийн шинэ хандлага байсан гэж хэлж болно.

Харамсалтай нь АНУ-ын одоогийн Ерөнхийлөгч зургаан талт хэлэлцээр БНАСАУ-д цөмийн зэвсэг бүтээх оролдлогыг хориглох асуудлуудад хэтэрхий хатуу байр суурьтай байж, олон удаа хориг тээг тавьж хугацаа ихээхэн алдсаны эцэст сүүлийн үед арга буюу тактикаа өөрчлөн БНАСАУ-ын шударга шаардлагыг хүлээн авч төлөөлөгчидтэй нь Вашингтон хотноо уулзаж хоёр талын хэлэлцээр хийхэд хүрсэн билээ. Түүгээр ч барахгүй 2007 оны 12 дугаар сарын эхээр АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш БНАСАУ-ын удирдагч Ким Чен Ир-т захидал бичиж Төрийн нарийн бичгийн даргын Зүүн Азийн асуудал хариуцсан туслах К.Хиллээр хүргүүлсэн нь дэлхийн олон орны анхаарлыг татсан чухал алхам боллоо. АНУ-ын Ерөнхийлөгч өмнө нь аливаа орны тэргүүнд хувийн захидал бичиж байгаагүй гэсэн үг ч сонсогдоод өнгөрлөө. Энэ дашрамд хэлэхэд Ким Ир Сений хүү, “ардын удирдагч” гэж алдаршаад байгаа Ким Чен Ир бол аавтайгаа адил зоримог, өөрийн гэсэн шинэ бодлого боловсруулж хэрэгжүүлэх боломжтой, хэт туйлширсан, үзэл сурталжсан хуучинсаг хандлагаас ангижирч дэлхийн орнуудад эдүгээ буй болсон хийгээд цаашид улам бүр гүнзгийрэх том өөрчлөлтүүдийг тусгасан прагматик үзэл баримтлалаар ажиллах удирдагч мөн бололтой хэмээн би хувьдаа боддог.

БНАСАУ, БНСУ-ын удирдагчид-Ким Чен Ир, Ро Му Хён нар 2007 оны 10 дугаар сарын 3-нд Пхеньян хотноо уулзаж хоёр орны найрсаг харилцааны хэтийн төлөвийн талаар түүхэн ач холбогдолтой хэлэлцээр хийсэн нь дэлхий нийтийн анхаарлыг зүй ёсоор татсан бөгөөд дараа нь Ерөнхий сайдууд, Гадаад харилцаа, Батлан хамгаалахын сайдууд бас уулзаж тодорхой асуудлуудыг нааштай шийдвэрлэсэн нь чухал ач холбогдолтой юм. Хоёр Солонгосын энэхүү тулгамдсан том асуудлыг шийдвэрлэх түүхэн цаг үед энэ талаар чамгүй их туршлага хуримтлуулсан, хэлэлцээрийн явцад буулт хийдгээрээ гарамгай Пан

Ги Мун НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа нь нэн завшаантай тохиолдол болж мэдэх талтай.



БНАСАУ-ын ерөнхийлөгч
Ким Чен Ир



Ким Чен Ир, Ро Му Хён
нарын уулзалт



БНСУ-ын ерөнхийлөгч
Ро Му Хён

Энэ нь 1948 оноос хойш хоёр Солонгосын удирдагчид хоёр дахь удаагаа нүүр тулан уулзаж байгаа хэрэг бөгөөд анх 2000 онд БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жүн Умард Солонгосын удирдагч Ким Чен Ир тэй Пхеньянд уулзаад Нобелийн Энх тайвны шагнал хүртэж байсан түүхтэй.

Хоёр Солонгосыг заагласан 38 дугаар өргөргийн хилийн боомтыг 2007 онд давахынхаа өмнө БНСУ-ын Ерөнхийлөгч Ро Му Хён сэтгүүлчдэд хандан “Би өнөөдөр энэ хилийн зурвасыг Ерөнхийлөгчийн хувиар давах гэж байна. Гэхдээ эрт орой хэзээ нэгэн цагт хилийн энэ зурвас газрын хөрснөөс арчигдаж элэг нэгтэй ах дүүсийг тусгаарлаж байгаа хориг саад арилна гэдэгт итгэлтэй байна” гэж мэдэгдсэн юм.

Гэвч 2007 оны 12 дугаар сарын сүүлчээр БНСУ-д Ерөнхийлөгчийн сонгууль болж 66 настай Ли Мен Бак үнэмлэхүй ялалт байгуулав. Тэрбээр “Цөмийн хөтөлбөрөө зогсоох талаар нь Хойд Солонгост шахалт үзүүлнэ” хэмээн мэдэгдэж АНУ-ын талархлыг хүлээсэн бөгөөд нэртэй бизнесмений хувьд эдийн засгийн шинэчлэл хийж улс орноо хямралаас гаргана гэж бас амлав. Ноён Ли Мен Бак Монголд элэгтэй нэгэн гэгдэж 2005 онд Улаанбаатарын хүндэт иргэн болсон, хоёр улс, хоёр нийслэлийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүчин зүтгэдэг хүн гэсэн таатай мэдээ бас сонсогдож байна.

XXI зууны эхэн үед болсон энэхүү түүхэн уулзалтын дараа БНАСАУ, БНСУ цаашдаа нэгдэж нэг улс болох саналаа НҮБ-д өргөн бариад байна. Гэвч энэ нь нэгэн дуугаар нэгмөсөн бүрэн шийдвэрлэгдэхгүй бөгөөд нэн ээдрээтэй, хоорондоо хурц зөрчилтэй, гэвч эерэг ба сөрөг нөлөөлөлтэй, нягтаар солибоцолдон сүлжигдсэн олон

хүчин зүйл, бодит ба субъектив шалтгаан, бэрхшээлүүдийг давж, он жилүүдийн явцад шийдвэрлэгдэх нь ойлгомжтой.

Тэдгээрийн дотроос юун түрүүнд, хүчирхэг гүрнүүдийн геостратегийн ашиг сонирхол, улс төр, үзэл сурталын зөрчил, хүйтэн дайны унтарч бүрэн дуусаагүй халуун нурамны цоргилт, хүчтэй нь хүчгүйгээ дарамтлан нухдаг уламжлалт бодлого зэргийг нэрлэж болох юм. Мөн үүний зэрэгцээ 1950-1953 оны том дайн, 50 гаруй жил үргэлжилсэн “хүйтэн” дайнаас улбаатай үл итгэлцэл, хардлага сэрдлэгэ солонгосчуудын сэтгэл санаанд оршоор байгаа, бас баян чинээлэг өмнөд солонгосынхон ядуу дорой амьдралтай умард солонгосынхноо хөгжилд маань дарамт, саад учруулна гэж тээршээдэг сэтгэл зүйн саад ч байгаа ажээ.

Хоёр Солонгос улс нэгдэх нь гарцаагүй бөгөөд тэгсэн үед эдийн засгийн нийлбэр чадавхи нь асар их өсөх болно.

БНАСАУ, БНСУ нийлээд 73 сая хүнтэй (Умард-24 сая, Өмнөд-49 сая), 220,6 мянган км² нутагтай (Умард-121 мян. км², Өмнөд-99.6 мян. км²), хилийн урт нь 2940 км, гурван талаасаа тэнгисээр хүрээлэгдсэн, олон мянган жижиг аралтай улс болох юм.

Хоёр Солонгос улс Номхон далайгаар бүс нутаг болон дэлхийн бусад оронтой холбогдож байгаа тул их, дунд даацын төрөл бүрийн усан онгоц үйлдвэрлэх, том хэмжээний усан боомтуудыг цаашид улам олноор байгуулж далайгаар хийх худалдаагаа нэмэгдүүлэх шинэ боломж нээгдэнэ. Тээвэр, далайн худалдаа, хөрөнгө оруулалт болон санхүүгийн нөөц, шинжлэх ухаан-технологийн асар их потенциал, эх газрын болон далайн гүний нөөц, загас агнуур, бараа борлуулах хязгааргүй том зах зээл зэрэг таатай нөхцлүүдийн улмаас ХХI зуунд Ази-Номхон далайн бүс нутаг олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн том төв болох таамаглал магадлал өндөртэй бөгөөд тэр үед нэгдсэн Солонгос улс улам ч хүчирхэгжинэ.

Алдарт “Капитал”-ыг туурвисан, дэлхийн нэрт эдийн засагч К.Маркс ХIХ зууны дундуур бичсэн нэгэн бүтээлдээ: “Олон улсын харилцааны аугаа их усан замын үүргийг эртний дэлхий дахинд Газрын дундад тэнгис гүйцэтгэж байв. Харин энэ үүргийг одоо Атлантын далай үүрч явна. Чухамдаа ирээдүйд энэхүү үүрэг нь Номхон далайд ноогдох болно”⁵ гэж бичсэн байдаг. Түүний таамаглал ХХI зууны эхэн үеэс уламч тодорхой болсоор байна.

⁵ К. Маркс, Ф. Энгельс. Соч. Т.3. стр. 323



БНСУ, БНАСАУ эвлэрэн нэгдсэний дараа ҮНБ-ий үйлдвэрлэл нь эрс өсөх бөгөөд одоогийн байдлаар зөвхөн БНСУ-ын ҮНБ нь дангаараа 1 триллион долларт дөхөж байна. Нэг хүнд 24 мянга гаруй доллар ҮНБ ноогддог өндөр хөгжилтэй орон гэдгийг дэлхий даяар мэддэг билээ. Олон шалтгааны улмаас Умард Солонгостой манай худалдаа, эдийн засгийн харилцаа 1990 оноос хойш бараг зогсонги байдалд орсон бол Өмнөд Солонгос Монголын гадаад худалдааны дөрөв дэх (Хятад, Орос, Японы дараа) гол түнш болоод байна.

Монголд байгуулсан аж ахуйн нэгж, компанийн тоо болон тэдгээрт оруулсан хөрөнгийн хэмжээгээр БНСУ 2 дугаар байранд ордог. Дэлхийн түвшинд авч үзвэл Өмнөд Солонгос гадаадын дэвшилт техник, технологийг бусад орноос их хэмжээгээр худалдан авч ухаалгаар адаптаци хийн үр бүтээлтэй ашигладаг тул дэлхийд телевизор үйлдвэрлэлээр 1 дүгээрт, хөлөг онгоцоор 2 дугаарт, гэр ахуйн цахилгаан бараагаар 3 дугаар байранд ордог гэсэн мэдээ буй. Гутал, нэхмэл бүс бараа, төрөл бүрийн бэлэн хувцасны үйлдвэрлэлээр мөн дэлхийд 3-4 дүгээр байранд ордог. Цахилгаан эрчим хүч гэхэд дэлхийн хэмжээгээр 30 улсад 435 атомын цахилгаан станц ажиллаж байгаагийн 4 нь БНСУ-д байдаг бөгөөд бүх төрлийн (ДЦС, АЦС, УЦС, салхины ЦС) цахилгаан станцын үйлдвэрлэсэн эрчим хүчний хэмжээгээр дэлхийд 6 дугаар байранд ордог болжээ.

БНСУ-ын экспортын 90 гаруй хувь нь иж бүрэн боловсруулсан, чанар, үзэмж сайтай, өрсөлдөх чадвар ихтэй, харьцангуй хямд бүтээгдэхүүн байдаг. Иймээс ч ган, уул уурхайн хүчирхэг техник, төхөөрөмж, шилэн кабель нь бүх талаараа нэрд гарсан ба энэ бүгдийн үр дүнд БНСУ дэлхийн хамгийн том экспортлогч 10 орны нэг болжээ.

Энэ бүгд бол БНСУ стратегийн чанартай техник, төхөөрөмж экспортлоход чиглэсэн бодлого боловсруулж, тууштай хэрэгжүүлсний нь үр дүн юм.

Хоёр Солонгос улс нэгдсэний дараа дотоодын интеграцлал, нэгдмэл эдийн засгийн цоо шинэ бүтцийг бүрдүүлэх эхний үе шатанд өндөр хөгжилтэй БНСУ-ын гүйцэтгэх үүрэг нэн чухал, магадгүй шийдвэрлэх ач холбогдолтой байх болов уу.

БНСУ, БНАСАУ нэгдсэний дараа эдийн засгаа хөгжүүлэх талаар урьд өмнө хэзээ ч байгаагүй таатай нөхцөл бүрдэх нь тодорхой боловч хоёул байгалийн баялгаар хомс учраас хөрш орнуудаас төдийгүй алс холоос, улс төрийн хувьд нэн тогтворгүй Ойрхи Дорнодоос стратегийн ач холбогдолтой түүхий эд их хэмжээгээр импортлож

боловсруулах явдал нь хэсэг хугацаанд үргэлжилсээр байж мэдэх юм. Эдүгээ БНСУ газрын тос, төмөр, хөнгөн цагаан, шатахуун зэрэг 20 гаруй нэр төрлийн металл, түүхий эдийг бараг 100 хувь гаднаас авдаг бололтой.

Гэтэл Монгол улс асар уудам нутагтай, хэвлий дэх баялаг нь даанч арвин их, мал сүрэг олонтой, түүнээс гардаг түүхий эд нь байнга нөхөгдөж байдаг давуу талтай. Үүний зэрэгцээ хоёр Солонгос улс газар зүйн байршлын хувьд ойр дөт учраас Монгол улс тэдгээрийг Европтой холбох нэг ёсны найдвартай гүүр болох бас нэг давуу талтай.

Энэ бүгдээс үзвэл Монгол улс ирээдүйн нэгдсэн Солонгос улсын аль алинд нь нийгэм, эдийн засгийн хөгжлөөс болон байгалиас буй болгосон давуу ба сул талууд байх тул түүнийг хоёр талаасаа харилцан нөхөж, шинэ давуу талуудыг буй болгох талаар түншлэх үзэл баримтлалыг үндэс болгох нь нэн чухал юм.

Монгол улс эдийн засгийн шинэ бүтэц буй болгох, өөрөөр хэлбэл улс орноо үйлдвэржүүлж орчин үеийн техник, технологид үндэслэсэн автоматжуулсан үйлдвэрлэл, үйлчилгээтэй болох замаар технологийн хоцрогдлоо аль болохоор хурдан арилгахын тул улс хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, зээл тусламж, интеграцлал, бүсчлэл, даяаршлын бүхий л эерэг нөлөөг үр бүтээлтэй ашиглаж богино хугацаанд их амжилтад хүрэх стратегийн зорилтоо хэрэгжүүлэхэд энэ бодлого нэн их ач холбогдолтой байх болно. Үүнийг шийдвэрлэх найдвартай арга замуудын нэг нь одоогоор Умард, Өмнөд хоёр Солонгосын дотоодын болон түүний нөлөө бүхий зах зээл дээр эрэлт хэрэгцээ ихтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хамтарсан үйлдвэрүүд байгуулах явдал юм. Энэ нь Монголд тэргүүний техник, технологи, бүр ноу-хауг ч хялбархан нэвтрүүлэх боломж олгоно.

Хоёр Солонгос улс нэгдсэний дараа эдийн засгаа бүхий л талаар интеграцлах, хүмүүсийнхээ амьдралын түвшин болон саланги байсан эдийн засгийнхаа чадавхийг хоршуулан жигдрүүлэх гэх мэт томоохон асуудлууд хурцаар тавигдахын зэрэгцээ зарим бэрхшээл тохиолдох нь гарцаагүй. Гэвч БНСУ шинээр үйлдвэржсэн өндөр хөгжилтэй орны хувьд тэр бүгдийг богино хугацаанд шийдвэрлэнэ гэдэгт эргэлзэх зүйл огтхон ч алга. Дэлхийн хөгжлийн глобаль хандлагыг соргоогоор тусган авч, өөрийнхөө онцлогт тохирсон удирдахын ухааны үзэл баримтлалыг боловсруулан хэрэгжүүлсний ачаар БНСУ, Европын капитализмын 300 жилд хийж бүтээсэн зүйлийг 30 жилд хийж 100 жилийг 10 жил болгон товчилж “эдийн засгийн нэгэн гайхамшгийг” харуулсан орон хэмээн эдийн засагчид, улс төрчид үздэг нь хоосон магтаал биш, үнэхээрийн бодит зүйл билээ. Манай улсын анхны Ерөнхийлөгч Монгол улсаа түүний адил Азийн нэгэн бар

болгоно гэж тунхагласан боловч сүүлдээ улс орноо үйлдвэржүүлэх үйл явцыг хувьчлал хийх замаар уналтанд оруулж, гадаадын бараа импортлогч, түүхий эд нийлүүлэгч орон болгоогүйсэн бол өнгөрсөн 20 шахам жилд нилээд бодит зүйл хийж бүтээсэн байх учиртайсан.

Эдүгээ Монгол улс, БНСУ, тэрчлэн БНАСАУ-ын аль аль нь ЗХА-ийн бүс нутагт эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграцийг хөгжүүлэх сонирхолтой байгаа боловч олон төрлийн саад бэрхшээлээс болоод олигтой үр дүнд хүрч чадахгүй байна. Гэхдээ энэ бүс нутгийн орнууд шинжлэх ухаан, техникийн асар их чадавхитай, газрын тос, шатдаг хий, байгалийн төрөл бүрийн эрдэс баялаг ихтэй, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн түгээх боломжтой тул энэ чиглэлээр олон улсын томоохон төслүүд боловсруулан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Тэдгээрт эхлээд Умард, Өмнөд Солонгос улс бие дааж, дараа нь нэгдсэн хүчээр оролцсон нөхцөлд манай талаас сүүлийн 10 гаруй жил ярьж, сонирхогч орнууд, НҮБ-аас оруулсан 1.5 тэрбум ам.доллар зарцуулаад тодорхой үр дүнд хүрч чадаагүй байгаа Түмэн голын сав газарт хэрэгжүүлэх төсөлтэй зүйрлэшгүй том хэмжээний бүтээн байгуулалтын ажил өрнөх нь дамжиггүй.


Умард, Өмнөд Солонгосыг нэгтгэх улс төр, эдийн засаг, нийгэм, хүмүүнлэгийн асуудал зөвхөн өнөөдөр тавигдаж буй цоо шинэ зүйл биш бөгөөд Ким Ир Сен тухайн үедээ эх орноо нэгтгэх 3 зүйлт үндсэн зарчмыг дэвшүүлж, улс орноо нэгтгэх үйл хэрэгт баримтлах удирдлагын чигийг боловсруулсан байна. Улмаар бүр 1960 онд тэрбээр “Холбооны Бүгд Найрамдах Солонгос (Корё) Улс (The Confederate Republic of Koryo)” нэрийн дор БНСУ-д санал тавих хэлбэрээр томъёолол гаргасан ажээ.

Хуваагдмал байгаа хоёр Солонгос улсыг нэгтгэх олон хувилбар байж болох бөгөөд тэдгээрийн дотроос эхний үед хамгийн боломжтой нь “нэг улс-хоёр систем” гэсэн шийдэл байж болох таамаглал магадлал өндөртэй болов уу. Энэ ухаалаг алхмыг БНХАУ хэрэгжүүлээд байгаа нь ээдрээтэй нарийн асуудлыг шийдвэрлэх нэг ёсны бэлэн загвар бус уу.

Хоёр Солонгос улс ямар нэгэн хэлбэрээр нэгдэх нь Солонгосын хойг төдийгүй, Зүүн хойд Ази, хөрш орнууд, дэлхийн улс гүрнүүдийн хөгжил, хүчний харилцаа, аюулгүй байдал хамтын ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх болно. Энэ талаар БНСУ-ын судлаач, дипломатч Шинь Сан Гюн “Түүхийн туршлагаас харахад Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудал Монгол улсын хувьд түүний өөрийнх нь үндэсний аюулгүй

байдалтай маш нягт холбоотой” явж ирснийг дурьдаад “Монгол улсын хувьд хүчирхэг гүрэн БНХАУ-ын цаана хүчтэй, нэгдсэн Солонгос улс гарч ирэх нь ч учир холбогдолтой юм”⁶ гэж тэмдэглэжээ. БНАСАУ, БНСУ нэгдвэл Зүүн хойд Азид асар их ирээдүйтэй, нэгэн шинэ улс гүрэн, хуваагдмал байдлаас ангижирсан аз жаргалтай үндэстэн буй болно. Улс төр, эдийн засаг, нийгмийн талаас нь авч үзвэл Зүүн хойд Азид томоохонд тооцогдох хүчтэй, нэгдсэн улс болох төдийгүй бүс нутгийн болон олон улсын асуудлыг шийдвэрлэхэд нөлөө бүхий шинэ хүчин зүйл гарч ирэх нь дамжиггүй.

БНАСАУ, БНСУ нэгдэж нэг улс болох үе шатуудын тухай хувийнхаа таамаглалыг дараах бүдүүвчээр тоймлон үзүүлэв.



2007 оны дэлхийн онцлох цөөн үйл явдлуудын нэг нь Умард, Өмнөд хоёр Солонгосын Ерөнхийлөгчид Пхеньянд уулзсан явдал байлаа. Улмаар хуваагдмал хоёр Солонгос улс, солонгосын ард түмэн XXI зуунд нэгдэн нэг улс гүрэн болж нэгэн гэр бүлд эвтэй найрсагаар амьдрах нь дамжиггүй.

⁶ Шинь Сан Кюн. БНСУ, Монгол улсын хоорондын харилцаа (1990-1999). Түүхийн ухааны дэд докторын зэрэг горилж бичсэн зохиолын хураангуй. УБ. 1999. 30 дахь тал